



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2017.08.25 № 11/3269

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
Т.БАДРАЛ ТАНАА**

Шадар сайдын 2017 оны “Мэргэжлийн  
ангийн дүрэм батлах тухай” 75 дугаар тушаалыг  
Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж,  
захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн  
бүртгэлийн 3780 дугаарт бүртгэснийг мэдэгдье.



С.БЯМБАЦОГТ

08 2121  
Doc.said a5.2017



## МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2017 оны 8 дугаар  
сарын 17 -ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар  
хот

Мэргэжлийн ангийн дүрэм  
шинэчлэн батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9, 28 дугаар зүйлийн 28.1.5-д заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Мэргэжлийн ангийн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү дүрмийг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгасугай.
3. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар /хошууч генерал Т.Бадрал/-т үүрэг болгосугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Шадар сайд

У.ХҮВЭЛСҮХ

## МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ДҮРЭМ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үеийн мэргэжлийн ангийн харилцаа, түүнийг байгуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2.Мэргэжлийн анги гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д зааснаар ойлгоно<sup>1</sup>.

1.3.Мэргэжлийн ангийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т зааснаар бүрдүүлнэ<sup>2</sup>.

1.4.Мэргэжлийн анги нь болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүч хэрэгсэл мөн.

1.5.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2-т заасныг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар, 33 дугаар зүйлийн 33.1.4, 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлагын шийдвэрээр тус тус мэргэжлийн ангийг байгуулна.

1.6.Мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, асуудлыг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллага хариуцна.

1.7.Хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох болон чиглэл өөрчлөгдөх тохиолдол нь тухайн мэргэжлийн ангийг татан буулгах, өөрчлөх үндэслэл болно. Хуулийн этгээд нь үйл ажиллагаа дуусгавар болсон талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

<sup>1</sup> Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017

<sup>2</sup> Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017

1.8.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлан шийдвэрлүүлнэ.

1.9.Бүх шатны нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь үйл ажиллагааны онцлог, хүчин чадлаас хамаарч энэхүү дүрэмд зааснаас гадна бүлэг, хэсгийг нэмж байгуулж болно.

1.10.Хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааны онцлог, хүчин чадалд нийцүүлэн мэргэжлийн ангийн зохион байгуулалт, хүн хүч, техник хэрэгслийн тоог тогтооно.

### **Хоёр. Мэргэжлийн ангийн зохион байгуулалт**

2.1.Мэргэжлийн ангийг зориулалтаар нь “ерөнхий” болон “тусгай зориулалтын”; харьяаллаар нь “төрийн” болон “хувийн хэвшлийн” гэж ангилна.

2.2.Сум, дүүргийн Засаг даргын захирамжаар ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг байгуулна.

2.3.Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг суманд 66-аас доошгүй, дүүрэгт 90-ээс доошгүй хүнтэй байхаар тус тус байгуулна.

2.4.Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлагын шийдвэрээр тусгай зориулалтын мэргэжлийн ангийг байгуулна.

2.5.Гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлага нь гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тусгай зориулалтын мэргэжлийн ангийн дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулж, мөрдөнө.

### **Гурав. Мэргэжлийн ангийн зориулалт**

3.1.Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги нь тухайн шатны нутгийн захиргааны байгууллагын шийдвэрээр орон нутгийн түвшинд болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

3.2.Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги нь эрэн хайх, аврах бүлэг, гал түймэр унтраах бүлэг, хэв журам сахиулах хэсэг, эрүүл мэндийн бүлэг, анхны тусламжийн хэсэг, механикжуулсан хэсэгтэй байна. /Хавсралт 1/

3.3.Тусгай зориулалтын мэргэжлийн анги нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүмүүнлэгийн тусламж, гал түймэр унтраах ажиллагаа, хэв журам, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт, түр болон хоргодох байрны үйлчилгээ, ус, дулаан, цахилгаан хангамж, санхүү, нөөц, хангалт, хүнс, хөдөө аж ахуй, зам гүүр засвар, инженер техник,



цацраг, химийн хяналт, харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа, иргэний бүртгэл, статистик, төмөр зам, нисэх буудлын аюулгүй ажиллагаа зэрэг чиг үүрэгтэй байна.

### 3.4. Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн чиг үүрэг

№	Мэргэжлийн ангийн зориулалт	Мэргэжлийн ангийн ангилал	Тухайн мэргэжлийн ангийн чиг үүрэг
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Яаралтай тусламжийн бүлэг	Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах
		Хээрийн эмнэлэг	Хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий л төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах
		Цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг	Нэрвэгдэгсдийг цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээгээр хангах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион байгуулах
		Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах бүлэг	Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах
		Зоонозын өвчинтэй тэмцэх бүлэг	Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхотгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах
		Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг	Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн анхны тусламж, дэмжлэг үзүүлэх, гамшгийн дараах стрессийг бууруулах, сэтгэл гутралыг багасгах, хүмүүсийн даван туулах итгэл найдварыг сэргээх, бусадтай харилцах, холбоо тогтооход нь туслах Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн эрэн хайх, аврах ажиллагааны багийн гишүүдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх
2	Нийгмийн хамгаалал	Хүүхэд хамгаалал, боловсролын бүлэг	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах
		Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг	Гамшиг, ослын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
3	Хүмүүнлэгийн	Дотоодын	Нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм, журмын дагуу

	тусламж	хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
		Олон Улсын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг	Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Олон Улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
4	Хэв журам сахиулах ажиллагаа	Хэв журам сахиулах бүлэг	Гамшиг, ослын үед нийгмийн хэв журам сахиулах, эрэн хайх, аврах ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэмийн үеийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах зэрэг бусад хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах
		Тусгай бүлэг	Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих, ухуулга, сурталчилгаа хийх
5	Санхүү, нөөц, хангалт	Санхүү, нөөцийн бүлэг	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зардлыг тооцох, шийдвэрлүүлэх Гамшиг, ослын үед шаардагдах төрөл бүрийн хангалтын нөөцийг холбогдох норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах, Хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангитай хамтран нөөцийн бараа бүтээгдэхүүнийг хуваарилах ажлыг зохион байгуулах
		Хүнсний хангалтын бүлэг	Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг ус, хоол, хүнсээр хангах
		Орон байр, хувцас хангалтын бүлэг	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсэд болон аврагч, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, орон байр, дулаан хувцас, хөнжил, гудас зэргээр хангах
		Тээврийн бүлэг	Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшиг, ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх
		Шатахуун, хийн түлш хангалтын бүлэг	Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа автомашин, бусад техник хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх, хангах, нөөц бүрдүүлэх
6	Нүүлгэн шилжүүлэлт, түр байр	Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны бүлэг	Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн

			тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах
7	Хоргодох байр	Хоргодох байрны бүлэг	Гамшиг, ослын /хүчтэй шуурга, цацраг, хими биологийн аюул/ үед хүн амыг түр байрлуулах хоргодох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах
8	Хүнс, хөдөө аж ахуй	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлэг	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг таңдалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх
		Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг	Химийн хоргүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор бэлчээрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавьж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, стандартын шаардлагыг хангуулах
		Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүлэг	Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх
9	Гал түймэр унтраах ажиллагаа	Гал түймэр унтраах бүлэг	Объектын болон ой, хээрийн түймрээс хүний амь нас, эд хөрөнгө, байгалийн баялагийг авран хамгаалах, гал түймрийг унтраах ажлыг зохион байгуулах
10	Усны сан бүхий газар, уст цэг хамгаалах ажиллагаа	Цэвэр, бохир усны засварын бүлэг	Цэвэр, бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх
		Уст цэг хамгаалах бүлэг	Усны эх ундарга, усны сан бүхий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усыг бохирдох, хор, халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх, харуул хамгаалалтад авах, үер усны аюулаас хамгаалах
11	Дулаан хангамж	Дулааны шугам сүлжээний засварын бүлэг	Дулааны эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
12	Цахилгаан хангамж	Цахилгаан, шугам сүлжээний засварын бүлэг	Гамшиг, ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугаманд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
13	Зам, гүүрийн засвар, үйлчилгээ	Зам, гүүрийн засварын бүлэг	Гамшиг, ослын улмаас нурсан, эвдэрсэн зам, гүүрт засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
14	Инженер, тэсэлгээ	Инженер, тэсэлгээний бүлэг	Аврах ажиллагаа зохион байгуулахад учирч буй саадыг арилгах зорилгоор тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэх.

			(цасны нуранги, мөсний хахаа зайлуулах, нурангинд дарагдсан зам гарцыг чөлөөлөх гэх мэт)
15	Цацраг, химийн хяналт	Цацраг, химийн хяналтын бүлэг	Гамшиг, ослын голомтод цацраг, химийн тандалт явуулах, үнэлэлт өгөх, цацрагийн түвшингийн хэмжилт хийх, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх
16	Харилцаа холбоо, зарлан мэдээлэл	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай холбоогоор хангах, холбооны шугамд гарсан гэмтлийг засварлах, сэргээн босгох, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртээ зарлан мэдээлэл дамжуулах
17	Мэдээлэл, сурталчилгаа	Мэдээлэл, сурталчилгааны бүлэг	Гамшиг, ослын нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах, гамшгийн үед иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах
18	Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгаа	Иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх
		Статистик мэдээллийн бүлэг	Мал амьтан, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн тооцоо судалгаа гаргах
19	Төмөр замын засвар, үйлчилгээ	Төмөр замын засварын бүлэг	Төмөр замын ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед аврах ажиллагаа зохион байгуулах, галт тэрэгний хөдөлгөөнийг сэргээх, мэргэжлийн бусад ажлуудыг гүйцэтгэх
20	Нисэх буудлын аюулгүй байдал	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг	Агаарын хөлгийн хөөрөх, буух үеийн аюулгүй байдлыг хангуулах, гамшиг, ослын үед нислэгийн бүсэд аврах, хор уршгийг арилгах, гал түймрийг унтраах, нийслэгийн зурвасыг сэргээн босгох ажлыг зохион байгуулах
21	Хуулийн этгээдийн мэргэжлийн анги	Анхны тусламжийн нөхөрлөл	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх
		Аврах, гал унтраах бүлэг	Гамшиг, ослын үед эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
		Ухуулга, сурталчилгааны бүлэг	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах

3.5. 50-иас дээш тооны ажилтан, албан хаагчидтай үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага нь анхны тусламжийн нөхөрлөл, аврах, гал унтраах бүлэг, ухуулга, сурталчилгааны бүлэг байгуулах бөгөөд гишүүдийг гүйцэтгэх чиг үүрэгт нь сургаж дадлагажуулах ажлыг тухайн байгууллага хариуцна.

#### **Дөрөв. Байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг**

4.1. *Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ:*



а.Гамшгийн өмнөх үед:

4.1.1.Мэргэжлийн ангийг байгуулж, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох;

4.1.2.Мэргэжлийн ангийг шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;

4.1.3.Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд мэргэжлийн ангийн оролцоог хангах;

4.1.5.Эрэн хайх, аврах ажиллагаанд зориулсан нисдэг тэрэгний хөөрөх, буух талбайг аймаг, сумын төвийн ойролцоо байгуулах, төхөөрөмжлөх;

4.1.6.Гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх

б.Гамшгийн үед:

4.1.7.Орон нутгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх, Онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах;

4.1.8.Гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангиар үүрэг гүйцэтгүүлэх;

4.1.9.Мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх;

4.1.10.Гамшиг, ослын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах;

Гамшгийн дараах үед:

4.1.11.Сэргээн босгох ажилд мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг нэгтгэн зохион байгуулах;

4.1.12.Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг нөхөн сэлбэх арга хэмжээ авах;

*4.2 Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллага дараах үүрэг хүлээнэ:*

а.Гамшгийн өмнөх үед:

4.2.1.Мэргэжлийн ангийг түшиглэн байгуулах сум, дүүрэг, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн жагсаалтыг гаргах;

4.2.2.Тухайн мэргэжлийн ангид томилгоожих бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт, хүч хэрэгслийн судалгааг нэгтгэх;

4.2.3.Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;

4.2.4.Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулахад дэмжлэг үзүүлэх;

б.Гамшгийн үед:

4.2.5.Гамшгийн голомтод мэргэжлийн ангийг удирдлагаар хангах;

4.2.6. Мэргэжлийн ангиудын хүч хэрэгслийг үүрэгт ажилд нь хуваарилах, нэгдсэн зохион байгуулалтаар хангах;

4.2.7. Мэргэжлийн ангиудын харилцан ажиллагааг жигдрүүлэх;

в. Гамшгийн дараах үед

4.2.8. Мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах, тайлан мэдээг нэгтгэх

*4.3. Гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн дарга (захирал) дараах үүрэг хүлээнэ:*

а. Гамшгийн өмнөх үед:

4.3.1. Мэргэжлийн анги байгуулах тухай шийдвэр гаргах;

4.3.2. Мэргэжлийн ангийг шаардагдах техник, тоног төхөөрөмж, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;

4.3.3. Томилгоожсон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;

4.3.4. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

б. Гамшгийн үед:

4.3.5. Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

4.3.6. Гамшгийн голомтод мэргэжлийн ангиар үүрэг гүйцэтгүүлэх, удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

4.3.7. Бусад төрөл, мэргэжлийн ангиудтай харилцан ажиллагаа явуулах;

4.3.8. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг амрах байр, цэвэр ус, хоол хүнс, бусад шаардлагатай зүйлсээр хангах;

4.3.9. Бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагааг хангах;

в. Гамшгийн дараах үед:

4.3.10. Мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах, тайлан мэдээг гаргах, Онцгой байдлын байгууллагад хүргүүлэх

4.3.11. Бэлэн байдлын үзлэг хийх, чадавхийг дээшлүүлэх

### **Тав. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бүтэц, гүйцэтгэх үүрэг**

5.1. Мэргэжлийн ангийн удирдлага нь:

- мэргэжлийн ангийн дарга;
- орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан;
- холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан;
- аюулгүй байдал хариуцсан ажилтан;
- хангалт хариуцсан ажилтан гэсэн бүтэцтэй байна.

5.2. Удирдах бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг

*5.2.1. Мэргэжлийн ангийн дарга дараах үүрэг хүлээнэ:*

а.Гамшгийн өмнөх үед:

5.2.1.1.Гамшгийн голомтод ажиллах мэргэжлийн ангийн тактикийн төлөвлөгөөг боловсруулах, тодотгох, хэрэгжүүлэх;

5.2.1.2.Жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн мэдээг маягтын дагуу гаргаж, харъяалах Онцгой байдлын байгууллагад хүргүүлэх;

5.2.1.3.Мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх саналыг боловсруулж, байгууллагын удирдлагад танилцуулах, гүйцэтгэх үүргийг тодорхойлох, нөөц бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа гаргаж, хангах асуудлыг шийдвэрлүүлэх;

5.2.1.4.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах /ОБЕГ-ын даргын 2016.05.10-ны өдрийн А/310 дугаар тушаалаар “Сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөө” батлагдсан/;

5.2.1.5.Мэргэжлийн ангийн бэлэн байдал, сэтгэл зүйн бэлтгэл, бүлэг, хэсгүүдийн харилцан шуурхай үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх;

5.2.1.6. Мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

б.Гамшгийн үед:

5.2.1.7.Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, нөхцөл байдлыг үнэлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.2.1.8.Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

5.2.1.9.Бусад төрөл, мэргэжлийн ангиудтай харилцан ажиллагааг зохион байгуулах;

в.Гамшгийн дараах үед:

5.2.1.10.Бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

*5.2.2.Мэргэжлийн ангийн даргын орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:*

а.Гамшгийн өмнөх үед:

5.2.2.1.Мэргэжлийн ангийн даргын эзгүйд түүний үүргийг орлон гүйцэтгэх;

5.2.2.2.Мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.2.2.3.Гамшгаас хамгаалах дайчилгаагаар ажиллах хүч, хэрэгслийн судалгаа гаргах, тодотгох, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;

5.2.2.4.Гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль явуулахад шаардлагатай танхим, дадлагын талбай бэлтгэх, бие бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль зохион байгуулах;

5.2.2.5.Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дээд шатны байгууллагын тушаал шийдвэр, албан даалгавар, сэрэмжлүүлэг, гамшиг, ослын нөхцөл байдал, хор уршгийг арилгах арга хэмжээний талаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдад таниулах, сурталчлах, гамшгийн аюулаас сэрэмжлүүлэх сурталчилгааны материалаар хангах зэрэг ажлыг зохион байгуулах;

б. Гамшгийн үед:

5.2.2.6.Гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, шийдвэр гаргахад мэргэжлийн ангийн даргад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, хөрш байгууллага, мэргэжлийн ангитай харилцан ажиллагааг зохион байгуулах;

5.2.2.7.Гамшгийн голомтод мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.2.2.8.Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

в.Гамшгийн дараах үед:

5.2.2.9.Мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах;

5.2.2.10.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

*5.2.3.Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:*

а.Гамшгийн өмнөх үед:

5.2.3.1.Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

5.2.3.2.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж шалгах, тухай бүр тодотгох;

5.2.3.3.Бие бүрэлдэхүүнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшүүлэх;

б. Гамшгийн үед:

5.2.3.4.Гамшгийн голомтод бүх төрлийн холбоо зохион байгуулах, мэргэжлийн ангийн даргыг холбоо, мэдээллээр хангах;

5.2.3.5.Дээд шатны байгууллагад гамшгийн нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах;

в.Гамшгийн дараах үед:

5.2.3.6.Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх, нөхөн сэлбэх;

*5.2.4. Аюулгүй байдал хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:*

а.Гамшгийн өмнөх үед:

5.2.4.1.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулах;

-5.2.4.2.Дайчилгаагаар ажиллах хүч хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах, хөдөлгөөн үйлдэх чиглэлийн талаар зааварчилгаа өгөх;

5.2.4.3.Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл түүний ашиглалт, хадгалалтад хяналт тавих, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийх;

5.2.4.4.Галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт болон хүчтэй үйлчилгээтэй хорт бодисын судалгааг гаргаж, бүртгэл хөтлөх, тэдгээрийн эргэлтэд хяналт тавих, объектын харуул хамгаалалтад хяналт тавих;

б. Гамшгийн үед:

5.2.4.5.Гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах;

5.2.4.6.Хүч хэрэгслийг гамшиг, ослын голомтод нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

5.2.4.7.Гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах ажилд дэмжлэг үзүүлэх.

в.Гамшгийн дараах үед:

5.2.4.8.Мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, аюулгүй байдлыг сайжруулах;

*5.2.5.Хангалт хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:*

а.Гамшгийн өмнөх үед:

5.2.5.1.Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, хангалтын төлөвлөгөө боловсруулах,

5.2.5.2.Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд ашиглагдах техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх;

5.2.5.3.Аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах;

б. Гамшгийн үед:

5.2.5.4.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг байр, цэвэр ус, хоол хүнс, эм, ороох боох материалаар хангах ажлыг зохион байгуулах;

5.2.5.5.Голомтод үүрэг гүйцэтгэж байгаа техник, тоног төхөөрөмжийг шатах тослох материалаар хангах;

в.Гамшгийн дараах үед:

-5.2.5.6.Хохирлын үнэлгээг хийж, мэргэжлийн ангийн даргыг мэдээллээр хангах;

5.3.Мэргэжлийн ангийн гишүүний үүрэг:

5.3.1.Мэргэжлийн ангийн гишүүн дараах үүрэг хүлээнэ:

а.Гамшгийн өмнөх үед:

5.3.1.1.Мэргэжлийн ангийн сургалт, дадлага сургууль, бусад нэгдсэн арга хэмжээнд оролцож өөрийгөө хөгжүүлэх;

5.3.1.2.Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ашиглах, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, холбооны хэрэгслийг ажиллуулах дадлага эзэмшсэн байх;

5.3.1.3.Хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах;

5.3.1.4.Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшсэн байх;

5.3.1.5.Аюулгүй ажиллагааны зааварчилгааг судлах;

5.3.1.6.Өөртөө болон бусаддаа тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байх;

б.Гамшгийн үед:

5.3.1.7.Удирдлагын шийдвэрээр гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх;

5.3.1.8.Аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах;

в.Гамшгийн дараах үед:

5.3.1.9.Эрүүл мэнд, сэтгэл зүйн эмчилгээнд хамрагдах

5.3.1.10.Хувийн бэлтгэлийг хангаж дараагийн томилгоот үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх;

### **Зургаа. Мэргэжлийн ангийн сургалт, бэлэн байдал**

6.1.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний сургалт, дадлага сургууль, бэлэн байдлын асуудлыг тухайн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлага шууд хариуцна.

6.2.Мэргэжлийн ангийн сургалт, дадлага сургууль зохион байгуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангахад шаардагдах зардлыг тухайн байгууллага хариуцна.

6.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, команд-штабын сургуульд мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг бүрэн оролцуулна.

6.4.Мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага хариуцан жилд 1 удаа зохион байгуулна.

6.5.Мэргэжлийн ангийн дарга нь гамшгаас хамгаалах сургалт, дадлага, сургуулийг бүлэг, хэсгүүдийн тусгай чиг үүрэгт нийцүүлэн, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан ангиллын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. Уг сургалт нь сургалтын төвд эсвэл тухайн байгууллага, аж ахуйн нэгж дээр явагдах бөгөөд танхимын сургалт /30 хувь/, дадлага сургууль /70 хувь/ гэсэн бүтэцтэй байна.



6.6.Мэргэжлийн анги нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу бэлэн байдлын зэрэгт шилжиж, удирдлагын шийдвэрээр үүрэг гүйцэтгэнэ.

6.7.Мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэгийг батлагдсан удирдамж, журмын дагуу төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс тухайн байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй хамтран жилд нэгээс доошгүй удаа явуулна.

### **Долоо.Мэргэжлийн ангийг байгуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмжийн хангалт**

7.1.Гамшгийн үеийн эрэн хайх, аврах үйл ажиллагааны санхүүжилт нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд зааснаар зохицуулагдана.

7.2.Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн техник, тоног төхөөрөмжийн хангалтад дараах хэрэгслүүд орно:

7.2.1.байгууллагын гамшгийн нөөц (ус, хүнс, хувцас, тоног төхөөрөмж);

7.2.2.цацраг, хими, биологийн тандалт, хяналтын багаж хэрэгсэл;

7.2.3.Хүн нэгж, бүрийн хамгаалах хэрэгсэл

7.2.4.хүн нэг бүрийн хээрийн иж бүрдэл;

7.2.5.голомтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл бүсийн тэмдэг тэмдэглэгээ;

7.2.6.гал унтраах багаж, хэрэгсэл;

7.2.7.инженерийн техник;

7.2.8.цэвэр, бохир ус болон дулааны шугам засварлах багаж, техник хэрэгсэл;

7.2.9.холбоо, зарлан мэдээлэх хэрэгслүүд, чанга яригч;

7.2.10.хээрийн гал тогоо;

7.2.11.гамшгийн үеийн удирдлагын хөдөлгөөнт болон суурин байр;

7.2.12.хээрийн эмнэлгийн байр, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм, ороох боох материал, ариутгадын бодисын нөөц;

7.2.13.гэр, майхан (хоргодох байр);

7.2.14.сургалт-арга зүйн гарын авлага гэх мэт.

7.3.Мэргэжлийн анги дараах үндсэн баримт бичгүүдийг хөтөлнө:

7.3.1.Мэргэжлийн ангийг байгуулсан тухай тушаал;

7.3.2.Мэргэжлийн ангийн орон тоо, бие бүрэлдэхүүний томилгоо;

7.3.3.Мэргэжлийн ангийн тактикийн төлөвлөгөө, тодотгол;

7.3.4.Мэргэжлийн ангийн зохион байгуулалтын бүдүүвч;

7.3.5.Мэргэжлийн ангийн чиг үүрэг, зориулалтыг тусгасан дотоод дүрэм, журам;

7.3.6.Зарлан мэдээлэх журам;

7.3.7.Бие бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын төлөвлөгөө;

7.3.8.Мэргэжлийн ангийн техник, багаж хэрэгслийн нөөц, хангалтын тооцоо;

7.3.9.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, штабын дадлагад оролцсон тухай тэмдэглэл;

7.3.10.Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгасан, шалгуулсан тухай тэмдэглэл;

7.3.11.Мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажилласан тухай тэмдэглэл;

7.4.Мэргэжлийн ангид хөтлөгдөх баримт бичгийг тухайн мэргэжлийн ангийн даргын томилсон албан тушаалтан хөтөлнө.

7.5.Мэргэжлийн ангийн хөтлөх баримт бичгүүдийн бүрдэлд төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс хяналт тавьж, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангана.

### **Найм. Бусад**

8.1.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн нь гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу албан томилолтын зардал авна.

8.2.Гамшгийн хор уршгийг арилгах ажилд оролцсон иргэн, сайн дурынхан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2, 37 дугаар зүйлийн 37.1.5-д заасан буцалтгүй тусламж, цалин, хөлс, томилолтын зардлыг авах эрхтэй.

8.3.Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, хуулийн этгээд нь мэргэжлийн ангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх саналаа Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад бичгээр ирүүлнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Нэг. Мэргэжлийн ангийн үйл ажиллагаа**

1.1.Гамшиг, ослын нөхцөл байдал үүссэн болон гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуулийн үеэр мэргэжлийн ангийн дарга болон холбогдох удирдах албан тушаалтны шийдвэрээр бие бүрэлдэхүүнийг “Яаралтай цугларах” дохиогоор цуглуулна.

1.2.Бие бүрэлдэхүүн тогтоосон хугацаанд, заасан байршилд томилгоожсон техник, багаж хэрэгсэлтэйгээр байрлана.

1.3.Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэхдээ мэргэжлийн ангийн дарга урьдчилсан байдлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.3.1.Гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэх тухай удирдлагын шийдвэрийг тодотгох;

1.3.2.Гамшиг, ослын хор хөнөөл, хүрээ, газар нутгийн онцлог, цаг агаарын болон бусад нөхцөл байдлыг үнэлэх;

1.3.3.Хүч хэрэгслийн чадавхыг үнэлэх;

- 1.3.4.Гамшиг, ослын голомтод хүрэлцэн очих зам, газар зүйн солбицол, хөдөлгөөн үйлдэх дарааллыг тогтоох;
- 1.3.5.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хамгаалах хэрэгсэл, цэвэр ус, хоол хүнсний хангалтыг тооцох;
- 1.4.Гамшиг, ослын голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг явуулахдаа доорхи хүчин зүйлийг тооцно. Үүнд:
- 1.4.1.Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны дарааллыг тогтоох, ажиллагааг идэвхитэй, тогтвортой, тасралтгүй зохион байгуулах;
- 1.4.2.Үүссэн нөхцөл байдал, гамшигтай тэмцэх арга хэмжээний үр дүнг орон нутгийн Онцгой байдлын байгууллага, шуурхай бүлгийн удирдлагад мэдэгдэх;
- 1.4.3.Тандалтын бүлэг болон бусад бүлгүүдтэй мэдээлэл солилцох, нөхцөл байдлыг нарийвчлан үнэлэх;
- 1.4.4.Бусад төрөл, мэргэжлийн анги, бүлэгтэй харилцан ажиллагааг зохион байгуулах,
- 1.4.5.Гэнэт үүссэн нөхцөл байдалд шуурхай хариу арга хэмжээ авах;
- 1.4.6.Нэмэлт хүч хэрэгсэл шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд мэдэгдэх;
- 1.4.7.Дайчилгаагаар хүч нэмэгдүүлж ирсэн бүлэг, хэсгийг чиглүүлэх;
- 1.4.8.Бие бүрэлдэхүүний амь нас эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлэх;
- 1.4.9.Аврах ажиллагааг эхлэх, дуусах хугацааг тогтоож, бие бүрэлдэхүүний амрах нөхцлийг бүрдүүлэх;
- 1.4.10.Нуранги, цахилгаан, дулааны шугамын эвдрэл, цацраг, химийн хордолт, гал түймэр, халдварт өвчин зэрэг аюулт үзэгдэл, ослын голомтын хорио цээрийн болон хязгаарлалтын бүсэд хийгдэх тэмдэглэгээ, хөдөлгөөн үйлдэх зам, гарц, дараалал, химийн бодисын тархалт, цацраг идэвхит бодисын дээд, доод хязгаарын тун, бусад нөхцөл байдлыг тооцох;
- 1.4.11.Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн талаар тайлан бэлтгэж, удирдлагд танилцуулах;
- 1.4.12.Хохирлыг тооцох;
- 1.5. Мэргэжлийн ангийн даргын шийдвэрийн зурагт:
- 1.5.1.Гамшиг, осолд өртсөн газар нутаг болон голомтын, сэжигтэй, эрүүл бүсийн хил хязгаар;
- 1.5.2.Үүссэн нөхцөл байдал, үүрэг гүйцэтгэж байгаа хүч хэрэгслийн мэдээлэл;
- 1.5.3.Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн боломж;
- 1.5.4.Нэмэлтээр хүч хэрэгслийг татан байршуулах тооцоо;

1.5.5.Хохирлын мэдээлэл зэрэг мэдээллийг тусгана.

### **Хоёр. Аюулгүй ажиллагаа**

2.1.Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд оролцож байгаа мэргэжлийн ангийн гишүүд нь гамшиг, ослын голомтод гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны зааврыг чанд сахиж, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадалд суралцсан байна.

2.2.Мэргэжлийн ангийн удирдлага нь голомтод гүйцэтгэх чиг үүрэгтэй нь холбогдуулан бие бүрэлдэхүүнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгч, гарын үсэг зуруулна.

2.3.Голомтын бүс дэх аюултай цэг, байршлыг тогтоож, тэмдэгжүүлнэ. Нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх, аврах ажиллагааны техник, багаж хэрэгслийг голомт руу хүргэх, гаргахдаа урьдчилан тогтоосон чиглэл, маршрутаар явна.

2.4.Аврах ажиллагааны зориулалтын техник, багаж хэрэгслийг ажиллуулах дадлага чадвар эзэмшээгүй хүнийг голомт руу нэвтрүүлэхийг хориглоно.

2.5.Цацраг, хими, биологийн аюултай бүсэд ажиллах мэргэжлийн ангийн гишүүдийг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангана.

2.6.Цацраг, химийн бодис тархсан голомтод ажиллах хугацаа дууссан эсвэл хордсон мэргэжлийн ангийн гишүүдийг ариутгал, халдваргүйтгэл хийж, голомтоос гаргаж, дараагийн бүлгийг голомт руу оруулна.

2.7.Бүлэг, хэсгийн дарга нар голомтын гарц дээр ээлж хүлээлцэх бөгөөд ээлж хүлээлгэн өгөх дарга дараагийн даргад нөхцөл байдлыг танилцуулж, мэдээлэл солилцоно.


2.8.Бүлэг, хэсгийг голомтоос гарсны дараа амрах бөгөөд шаардлагатай тохиолдолд дараагийн ажиллагаанд бэлтгэнэ. Голомтод ажилласан техник, багаж хэрэгсэлд засвар үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэл хийж, хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгслийг сольж нөхөн хангалт хийнэ.

----О----



## МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮТЭЦ

### Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги





**Тусгай зориулалтын мэргэжлийн анги**

